

ЭМГЭНЭЛ
НАЦАГДОРЖИЙН БАТБИЛЭГ
/1977-2018/

Бидний дотны нөхөр хамтран зүтгэгч Завхан аймаг дахь Төрийн Аудитын Газрын аудитор Нацагдорж овогтой Батбилэг нь 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдөр зуурдаар таалал төгсч бид бүхэнд нөхөж баршгүй хүнд гарз учирсанд гэр бүл, үр хүүхэд, аав, ээж, төрөл төрөгсдөд нь гүн эмгэнэл илэрхийлье.

Аудитор Н.Батбилэг нь хариуцсан ажил үйлсдээ чин сэтгэлээрээ зүтгэж ирсэн, хамт олныхоо дунд нэр хүндтэй үлгэр дууриал болсон аудитор билээ.

Тэрээр 1977 онд Завхан аймгийн Эрдэнэхайрхан суманд Нацагдоржийн ууган хүү болон мэндэлжээ. Н.Батбилэг нь 1985-1993 онд Эрдэнэхайрхан сумын дунд сургууль, 1993-1995 онд Элдэв-Очирын нэрэмжит 10 жилийн 1-р сургууль, 1995-1999 онд МУИС-ийн Завхан аймаг дахь Эдийн засгийн сургуулийг нягтлан бодогч эдийн засагч мэргэжлээр, 2009-2011 онд Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийг бизнесийн менежмент мэргэжлээр тус тус төгссөн, бизнесийн удирдлагын магистр, Монгол Улсын Мэргэшсэн Нягтлан Бодогч, Мэргэшсэн Дотоод Аудитор билээ.

Хөдөлмөрийн гараагаа 2000-2005 онд Завхан аймгийн Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төвд нягтлан бодогч, оператороор ажиллаж эхэлсэн бөгөөд 2007 оноос Завхан аймаг дахь Төрийн Аудитын Газар шинжээч, 2010 оноос аудитороор өнөөг хүртэл ажиллаж байлаа.

Н.Батбилэгийг Монгол улсад Төрийн хяналт аудитын тогтолцоог хөгжүүлэн бэхжүүлэх үйлсэд оруулсан хувь нэмрийг үнэлж, "Төрийн хяналтын тэргүүний ажилтан", "Санхүү банкны тэргүүний ажилтан", Сангийн Яамны "Хүндэт жуух", Үндэсний Аудитын Газрын "Хүндэт жуух" бичгээр тус тус шагнаж байжээ.

Талийгаачийн хөдөлмөрч, ажилч хичээнгүй, нөхөрсөг, төлөв даруу зан чанар бидний сэтгэл зүрхэнд үүрд хоногшин үлдэх болно.

УМ САЙН АМГАЛАН БОЛТУГАЙ

Завхан аймаг дахь Төрийн Аудитын Газар